

НӨӨЦ БАЯЛГИЙН ХАРААЛ БА МОНГОЛ УЛС

С. Энхцэцэг¹

Нөөц баялагийн хараал, түүнийг тойрсон асуудлууд

Байгалийн баялаг элбэг байх нь эдийн засгийн өсөлт, хөгжилд сөргөөр нөлөөлдөггүй болохыг АНУ, Канад, Австрали, Чили, Норвеги, Индонез, Ботсвани зэрэг орны нөөц баялагт тулгуурлан амжилттай хөгжсөн түүхэн маргашгүй жишээнүүд харуулна. Гэвч газрын тос болон бусад ашигт малтмалын нөөцөөс хэт хараат улсад (ихэвчлэн нийт экспортын 60-95 хувийг эрдэс баялаг эзэлж байвал) нөөц баялгийн хараал хэмээх үзэгдэл түгээмэл байдаг байна. Асуудлын гол нь баялгийн өвөрмөц шинж чанарт бус харин түүнээс бий болсон баялгийг хэрхэн хуваарилж, ашиглаж байгаад оршино. Газрын тос, ашигт малтмалаас хараат орнуудад голчлон тулгардаг энэхүү хачирхалтай үзэгдлийг “элбэг дэлбэгийн гаж үзэгдэл”, “нөөц баялгийн хяслан”, “байгалийн нөөцийн гаж үзэгдэл”, “байгалийн нөөцийн хараал” хэмээн судлаачид янз бүрээр нэрлэдэг.

Нөөц баялаг ихтэй хөгжиж буй орнууд нөөц баялаг хомс улс орнуудаас хөгжлөөр хоцорч байгааг² сүүлийн үеийн олон судалгаа харуулаад байна. Нөөц баялгийн хяслан гэдэг нь байгалийн баялгаас ихээхэн хараат байдал, эдийн засгийн өсөлт хоёрын хооронд орших урвуу хамаарлын тухайд яригдаж байгаа юм. Гэвч нөөц баялаг бүр адилхан байдаггүй. Газрын тос, ашигт малтмал гэх мэт газар зүйн буюу эдийн засгийн хязгаарлагдмал бааз сууринаас олборлодог байгалийн баялгийн экспортоос хараат улсуудын эдийн засгийн өсөлт удаан байх нь элбэг байна.

Газрын тос, ашигт малтмалд тулгуурласан нөөц баялаг ихтэй орнууд хөрөнгө оруулалт ба импортын өндөр чадавхитай байдаг ч хамгийн сул дорой өсөлттэй орнуудын тоонд ордог. 1965-1998 онд ОПЕК-ийн гишүүн орнуудын нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн нь жилд дунджаар 1.3 хувиар буурсан байхад, мөн хугацаанд газрын тосны баялаггүй хөгжиж байгаа орнууд нийтээрээ жилд дунджаар 2.2 хувийн өсөлттэй гарчээ.³ Барууны дийлэнх судлаачид газрын тос, ашигт малтмалын нөөцөөс хэдий чинээ их хамааралтай байна, төдий чинээ өсөлт муутай байдгийг нэгэн дуугаар баталсан байх юм.

Нөөц баялгийн хяслан, түүний шалтгаан:

Энэхүү эдийн засгийн гаж үзэгдлийг янз бүрээр тайлбарладаг бөгөөд тэдгээр нь ихээхэн маргаантай байдаг. Дараах хүчин зүйлс ихээхэн нөлөөлдөг хэмээн судлаачид санал нэгтэй үзжээ. Үүнд:

1. Түүхий эдийн үнийн тогтворгүй байдал: Түүхий эдийн зах зээл хамгийн тогтворгүй байдаг тул бодлого боловсруулагчдын хувьд үнийн гэнэтийн хөөрөгдөлт, тухайн үеийн эдийн засгийн мөчлөгийг үр нөлөөтэй удирдахад төвөгтэй байдаг байна. Үнийн тогтворгүй байдал нь төсвийн сахилга бат, төр засгийн санхүүгийн хяналт, бодлого төлөвлөлтөд хүчтэй нөлөөлөл

¹ МУИС, ОУХС-ийн багш

² Jeffrey Sachs & Andrew Warner: in series of papers (1995, 1997 and 1999) www.islor.org

³ “Газрын тосны тухай бичихүй” С.Батбаяр орчуулсан., Нээлтэй Нийгэм Форум. 2004 он., х.15-16

үзүүлдэг тул үр ашигтай хөрөнгө оруулалтыг боомилох, орлогын оновчтой хуваарилалтыг алдагдуулах, ядуурлыг улам бүр нэмэгдүүлэхэд нөлөөлдөг байна. Байгалийн баялгийн олборлолт, экспортоос олж буй орлогыг бүрдүүлэх, зарцуулахад олон нийтийн болон хууль тогтоох байгууллагын хяналтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байдаг. Нөөц баялгийн олборлолт нь орлогын эх үүсвэр шавхагдахад хүргэж болох тул нөөц баялгаас хамааралтай орнуудын засгийн газар баялгийн үйлдвэрлэл, экспортоос олж байгаа орлогоо бусад орлогын эх үүсвэрээр орлуулах нь чухал байдаг байна.

2. Голланд өвчин: Голланд өвчин буюу ашигт малтмалын салбар дотоодын валютын ханшийг чангаруулснаар бусад экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг бууруулдаг байна. Үүний үр дүнд ашигт малтмалын экспорт нь бусад өрсөлдөх салбарын, ялангуяа хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг шахаж, эдийн засгийн бүтцийг олон салбарт төрөлжүүлэн хөгжүүлэхэд саад учруулдаг.⁴ Бодлого боловсруулагчид энэ асуудлыг зохицуулахын тулд өрсөлдөх чадвар сул бусад эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих үүднээс ашигт малтмалын салбартаа санхүүжилтийн ачаа үүрүүлэх замаар хамгаалалтын хүчтэй бодлого баримталдаг байна. Үүний үр дүнд хөдөө аж ахуйн болон үйлдвэрлэлийн салбарууд ашигт малтмалын салбарын шилжүүлгээс хамааралтай болж эхэлмэгц, түүнээс хараат байдал улам даамжирч, хөрөнгийг илүү үр ашигтай зарцуулах хандлагыг сулруулж яваандаа өрсөлдөх чадвараа бүр мөсөн алдахад ч хүргэдэг талтай.

3. Капитал ба технологийн хувьд ашигт малтмалын салбар нь цөөн тооны ажлын байр бий болгохын зэрэгцээ эдгээр ажлыг хийхэд шаардагдах ур чадвар өндөр байдаг тул орон нутгийн ажилгүйчүүдийн мэргэжил туршлагад тохирдоггүй байна. Тиймээс орон нутгийн иргэдийг ажлаар хангахын оронд, өндөр ур чадвартай ажилтнуудыг гадаадаас авчирч ажиллуулах зэргээр *“хийж үзэж байж суралцах”*-ын асар их ашиг тусаас салгадаг нь эдийн засгийн хөгжилд учруулдаг нэг гол бэрхшээл юм.

Харин нөөц баялаг хомс орнуудад боловсролын эрэлт хэрэгцээ үйлдвэрлэлийн салбарт их байдаг тул арга туршлагын хуримтлал илүү хурдан явагдаж, баян ядуугийн ялгаа бага гарах хандлагатай байдаг нь дан ганц ашигт малтмалын орлогын санхүүжилтээр бус, харин хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэний үр дүнд эдийн засгийн өсөлт нэмэгддэгтэй холбоотой юм. 2003 онд НҮБ-аас гаргасан Арабын хүний хөгжлийн хоёрдугаар тайланд Ойрхи Дорнодын зарим улс орнуудын газрын тосноос ихээхэн хамааралтай байдал нь *“баялаг цөөн хүний гарт хэт төвлөрд”, “эдийн засгийн өсөлтийг доголдуулан”, “мэдлэг чадварын эрэлт хэрэгцээг сулруулсан”* явдлаас үүдэлтэй хэмээн дүгнэжээ.

4. Татварын асуудал: Ашигт малтмалын төслүүд томоохон цар хүрээтэй, капиталын нягтрал ихтэй, гадаад эзэнтэй байдаг учраас хүлээн авагч орны эдийн засгийн бусад салбаруудтай нягт уялдаа холбоо муутай байдаг. Ашигт малтмалын олборлолтын орлого нь гадаадын компаниудын төлсөн нөөцийн төлбөр, улсын үйлдвэрийн газруудын татвар зэргээс голчлон бүрддэг тул ашигт малтмалаас тусдаа татварын тогтолцоо бий болгох сонирхолгүй болгож, улмаар ашигт малтмалаас хараат байдлыг улам бүр нэмэгдүүлдэг.

5. Төсвийн ил тод бус байдал: Дэлхийн 85 улсыг хамарсан төсвийн ил тод байдлын өргөн хүрээтэй үнэлгээ болох Нээлттэй төсвийн судалгаа 2008-д нөөц баялгаас хамааралтай улс орнуудын төсөв нөөц баялгаас хамааралгүй орнуудтай харьцуулахад ил тод байдал сул байдгийг тогтоосон байна. Судалгааны багц асуултад тулгуурлан төсвийн тухай гол чухал мэдээллүүдийн хүртээмжтэй, иж бүрэн байдлыг харьцуулан хэмждэг Нээлттэй төсвийн индексэд (НТИ) нөөц баялгаас хамааралтай орнууд 2008 оны нийт 100 оноо авахаас дунджаар 31 оноо авсан бол нөөц баялгаас хамааралгүй орнууд 45 оноо авчээ. Судалгааны тоо баримтуудаас үзвэл нөөц баялгаас хамааралтай орнууд тааруухан амжилт үзүүлсэн нь газрын тос, байгалийн хийн томоохон үйлдвэрлэгчид тооцогддог 22 улсад ил тод, хариуцлагатай байдал дутагдсанаас ихээхэн хамаарчээ. Тэдний дундаж оноо дөнгөж 100-аас 22 байсан бол харин ашигт малтмалын

⁴ W.M.Corden: "Booming sector and Dutch Disease Economics: Survey and Consolidation" Oxford Economic Papers 36(1984), 359-380
www.jstor.org

нөөцөөс хамааралтай орнууд нөөц баялгаас хамааралгүй орнуудтай бараг ижил 47 оноо авчээ. Газрын тосоор баян орнууд газрын тосны үйлдвэрлэл, экспортоос олсон орлогоо гол төлөв төсвөөс гадуур байлгадаг нь тэрхүү гэнэтийн их орлогыг хэрхэн зарцуулж байгааг олон нийт хянах боломжийг улам бууруулдаг байна.

Хүснэгт 1. Олборлох үйлдвэрлэлийн орнуудын үзүүлэлт, ангиллаар⁵

Ангилал	Газрын тос үйлдвэрлэгчид	Ашигт малтмал үйлдвэрлэгчид	Нөөц баялгаас хамааралгүй орнууд
Орлогын тогтворгүй байдал ба урьдчилсан таамаглалт	25	63	54
Зарлагын хяналт	22	52	48
Бодлого, төлөвлөлт, төсвийн уялдаа холбоо	17	37	35
Төсвөөс гадуурх үйл ажиллагаа	20	31	32

Байгалийн нөөц баялагтай улс орнууд ч гэсэн олон нийтийнхээ өмнө ил тод, хариуцлагатай байж чаддагийг Өмнөд Африк, Норвеги, Ботсвани, Перу улсууд харуулж байгаа тул байгалийн нөөцөөр баян бол эдийн засгийн өсөлт удаан, хөгжлийн үр дүн тааруу байна гэж шууд дүгнэж болохгүй юм. Ил тод байдал дутагдах нь дунд хугацааны нөөц баялгийг тааруухан удирдахад хүргэж улмаар тухайн улс олон улсын эдийн засгийн интеграцчилалд нэгдэн ороход саад учруулж болохыг 2008 оны НТИ-д 100-аас 1 оноо авсан Саудын Арабын жишээ харуулж байна.

Хэдийгээр төсвийн бодлого сайтай хэмээн тооцогддог ч Саудын Арабт хамгийн өндөр оноо өгөхөөс олон улсын зэрэглэл тогтоогч агентлагууд татгалзжээ. Хэдийгээр байгалийн баялаг хөгжилд хүрэх түлхүүр мөн ч түүнээс олсон асар их хэмжээний баялагийг зүй зохистой удирдаж чадахгүй аваас ядууралд хүргэж ард түмнийг туйлдуулдах ч эрсдэл байдгийг дээрх судалгааны үр дүн харуулж байна.

Ашигт малтмалын олборлож ашиглахтай холбоотой аливаа яриа хэлэлцээ, гэрээний нөхцлийн талаар нийтэд ил болгосон мэдээлэл ихэвчлэн хомс байдаг учраас *хэлэлцээний ширээний ард сууж байгаа аль ч тал зохисгүй үйлдэл хийх боломжийг олгодог* нь томоохон асуудал үүсгэх үндэс болдог. Ихээхэн унацтай тендерт оролцож байгаа компаниуд голдуу *зүсээ хувиргасан* засгийн газрын албан тушаалтнууд, тэдний төлөөлөгчдөд тал засах үүднээс хууль бус төлбөр хийх нь түгээмэл байдаг. Иймд ашигт малтмалаас хараат байдал нь илүү үр бүтээлтэй бусад үйл ажиллагаанд саад тотгор болохын зэрэгцээ татвар төлөгчдийн эрэлт хэрэгцээ, судалгаа шинжилгээнд зайлшгүй шаардагдах хариуцлагатай байдлыг алдагдуулдаг. Тиймээс нөөц баялгийн хяслангаас зайлсхийхийн тулд үнийн хэлбэлзлийг тэгшитгэж чадахуйц бараа, түүхий эдийн тогтворжуулалтын сан байгуулах, Голланд өвчнийг намдаахын тулд эдийн засгаа улам нээлттэй болгож гадаад валютын боловсронгуй бодлого баримтлах, хүний нөөцөд, ялангуяа боловсрол, ур чадвар олгоход илүү үр нөлөөтэй хөрөнгө оруулалт хийх, илүү ил тод байдал бий болгож татварын шинэ бодлого хэрэглэх зэрэг төрийн бодлогыг явуулахыг судлаачид анхааруулжээ.⁶

Ашигт малтмалын баялгийг үр нөлөөтэй ашиглах амаргүй. Эдгээр бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд чадварлаг төр засаг, институцчиллыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байдаг. Институциуд нь сул дорой, төр засгийн тогтолцоо бүрэн бүрдээгүй тохиолдолд ашигт малтмалын орлого цутган орж ирэх нь түүнээс олох ашгаар амьдардаг, бусдын гар харж

⁵ www.forum.mn

⁶ Robert M.Solow: "The Economics of Resources or the Resources of Economics" www.jstor.org


бэлэнчлэгч төр засаг төрүүлэх хандлагатай. Ийм бэлэнчлэгч төрд эдийн засгийн нөлөө ба улс төрийн эрх мэдэл нэг дор төвлөрч, улсын ба хувийн ажлын зохих уялдаа холбоо алдагддаг. Эрх баригчид орж ирж буй орлогыг өөрсөддөө болон дэмжигчиддээ татаас, хамгаалалт, төрийн албан тушаал болгон олгох, зардал хэтрүүлэх зэргээр нааш цааш болгон эрх мэдлээ бэхжүүлэн, нөлөөгөө хэвээр хадгалах хандлагатай байдаг. Мөн ашигт малтмал экспортлогч орны төр засаг хэт томорч тэлэхийн зэрэгцээ хүн амынх нь дунд гар харах үзэгдэл дэлгэрэх ужиг хандлагатай байдаг. Харин нөөц баялаг багатай орнуудад тэрхүү хомс нөөцийн ашиглалтад бүх нийтийн хатуу хяналт, шахалт шаардлага тавьдаг тул үр ашиггүй байдал, идэж завших явдлыг газар авхуулдаггүй бөгөөд тийм эдийн засагтай улс өргөн хүрээтэй хамгаалалт, хэт газар авсан хүнд суртлыг тэвчдэггүй тул сайн институцийг нэвтрүүлсэн байдгаараа давуу талтай.

Байгалийн нөөцийн гэж үзэгдэл ба Монгол улс

2005 оны байдлаар дэлхийн уул уурхайн салбарт хамгийн их хөрөнгө оруулалтыг татсан 10 орны тоонд Монгол улс багтсан байна. AngloGold, BHP Billiton, Cameco, Rio Tinto, Mitsui зэрэг уул уурхайн дэлхийн тэргүүлэх компаниуд Монголд хөрөнгө оруулж, үйл ажиллагаагаа явуулж эхэллээ. Монгол дахь олон улсын хөрөнгийн корпорацийн мэдээлснээр Монголд ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 18 компани Торонтогийн биржид хувьцаагаа гаргадаг бөгөөд Монголд хамааралтай хөрөнгийн хэмжээ нь 2.5 тэрбум доллар ажээ.⁷

Байгалийн нөөцийн хяслан нөөц баялгаас ихээхэн хамааралтай улс орнуудад дараах 4 сувгаар дамжин хүрдэг хэмээн судлаачид үзжээ.⁸ Манай улсын хувьд ямар байгааг авч үзье.

Зураг 1



1. Монгол дахь голланд өвчин: Экспортын бүтцийн 70 орчим хувь нь алт, зэс, ноолуур гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүнээс бүрдэж байгаа нь гадаадын үнийн шоконд хэт өртөмтгий байдлыг үүсгэж байна. Экспортын гол бүтээгдэхүүн болох алт, зэсийн үнэ дэлхийн зах зээлд огцом буурснаас худалдааны томоохон алдагдал хүлээж байна. Түүнчлэн нэг талт /нэг салбар, нэг бүтээгдэхүүн голлосон/ эдийн засгийн бүтэц нийгэм, эдийн засгийн байдлыг улам бүр

⁷ Д.Шүрхүү: “Эрдэс баялагийн геополитик” Олон улс судлал сэтгүүлийн 2006 оны дугаар

⁸ Elissaios Papyrakis and Reyner Gerlagh: “The resource curse hypothesis and its transmission channels” www.elsevier.com


эмзэг болгож байна.

Дан ганц уул уурхайн салбар давамгайлж аж үйлдвэрийн боловсруулах салбар уналтанд ороод байгаа нь эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж эрсдлийг бий болгож байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2009 оны 1 дүгээр сарын байдлаар 298.0 сая ам.доллар, үүнээс экспорт 170.4 сая, импорт 127.6 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 42.7 сая ам.долларын ашигтай гарлаа. Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеийнхээс 40.9 сая ам.доллараар, 2008 оны 12 дугаар сарынхаас 106.2 сая ам.доллараар тус тус өсчээ.

Гадаад худалдааны тэнцэл хэдийгээр ашигтай гарсан ч нийт бараа эргэлт өмнөх оны мөн үеийнхээс **30.9 хувь, экспорт 21.3 хувь, импорт 40.6 хувиар тус тус буурчээ.** Үүнд экспортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг эрдэс бүтээгдэхүүн 60.5 сая ам.доллараар; түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл 3.4 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ.⁹

Гадаад худалдааны нийт эргэлтийн хэмжээ



2009 оны 1-р сард экспорт 21.3, 2-р сард 71, 3-р сард 38.6 хувиар тус тус буурчээ. Нийт экспорт багассаны гол шалтгаан нь экспортын орлогын 33 хувийг бүрдүүлдэг зэсийн дэлхийн үнэ огцом унасантай холбоотой. Тухайлбал, 2008 оны 4-р сард нэг тонн зэсийн дэлхийн үнэ 8685 ам. доллар байсан бол 2009 оны 1-р сар гэхэд 3125 ам. доллар болж 64 хувиар буурсан байна.

Мөн 2008 оны 1-р сарын байдлаар нэг тонн цайрын баяжмалын үнэ дунджаар 1266.9 ам.доллар байсан бол 2009 оны 1-р сард 546.0 ам.доллар болж 56.9 хувиар буурсан. Экспорт буурсан хоёрдогч гол шалтгаан бол алтны экспорт 40 хувиар буурсантай холбоотой ажээ. Импортын хэмжээ 2008 оны 12-р сард 9.8 хувиар буурч эхэлсэн бөгөөд зөвхөн нэг сарын дараа гэхэд импортын нийт хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 40 хувиар буурсан байна. 2009 оны эхний улирлын турш экспортын хэмжээний уналт нь импортын хэмжээний уналтаас их байна.¹⁰

2. Монгол дахь авилгал: Манай улс авилгалын үзүүлэлтээрээ улам бүр байр ухрах болсон нь сүүлийн жилүүдийн олон улсын байгууллагаас гаргасан судалгаанаас харагдаж байна. Рент хайх (Rent-seeking) үзэгдэл буюу эдийн засгийн гажуудлаас ашиг олох гэсэн үйл ажиллагаа газар авснаар хувийн хэвшил, төр засгийг авилгалд өртүүлж, улмаар нөөцийн хуваарилалтыг гажуудуулж, эдийн засгийн болон нийгмийн бүтээмжийг бууруулдаг явдал


⁹ www.nso.mn Монгол Улсын эдийн засаг, нийгмийн байдал (2009 оны 1 дүгээр сарын байдлаар)

¹⁰ Санхүү, эдийн засгийн хямрал: Монгол улс 2009 оны эхний улирлын тайлан, Нээлттэй нийгмийн хүрээлэн. х.35

манайд шийдэгдэхгүй байгаа нь авилгалыг улам бүр гүнзгийрүүлэх үндэс болж байна.


3. Монгол дахь хөрөнгө оруулалт: 1990 оноос манай улсад хийгдсэн нийт хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь уул уурхайн салбарт төвлөрсөн тул бусад салбарын өрсөлдөх чадварыг улам сулруулж ашигт малтмалын салбараас хэт хамааралтай байдлыг бүрдүүлсэн юм. Мөн хөрөнгө оруулагч улс орнуудын хоорондын тэнцвэрт байдлыг хангах нь манай үндэсний аюулгүй байдлын үндэс тул хөрш хоёр улс болон гуравдагч орнуудаас хөрөнгө оруулалтын урсгалыг нэвтрүүлэхдээ ихэд болгоомжтой хандах нь чухал юм.

Зураг 2. Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ/1990-2005/



Эх сурвалж: Гадаадын хөрөнгө оруулалт гадаад худалдааны агентлаг

Зураг 3. Гадаадын хөрөнгө оруулалтын гарал үүсэл /1990-2006/



Эх сурвалж: Гадаадын хөрөнгө оруулалт гадаад худалдааны агентлаг

4. Монгол улсын боловсролын салбарын хөгжил: Хүний нөөцийн сул байдал нь байгалийн нөөцийн хараал газар авах гол шалтгаан болдог байна. Байгалийн нөөц олборлолтын ашиг их байх тусам хүний нөөцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх сонирхол бага байдаг байна.

Байгалийн нөөц баялаг залхуурлыг дэвэргэдэг бол байгалийн хомсдол нь шинэлэг санааг хөгжүүлэхэд түлхэц болдог ажээ.¹¹ Эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжил бүрдүүлэхэд боловсролтой чадварлаг ажиллах хүчнийг бэлтгэж улмаар ажлын байраар хангах явдал нэн чухал байдаг.

Байгалийн нөөц баялаг элбэгтэй улс орнууд технологийн хөгжлийг нутагшуулж, эдийн засгаа төрөлжүүлэн аж үйлдвэрийн өрсөлдөх чадвараа дээшлүүлэн хөгжүүлж чаддаггүй нь чадварлаг ажиллах хүчний анги бэлтгэж чаддаггүйд оршдог байна.

Гэнэтийн ашгаас олсон орлогоос эдийн засгийг төрөлжүүлэхэд зарцуулах нь төдийлөн өндөр үр дүн багатай, харин боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц зэрэг салбарт төвлөрүүлэх нь ирээдүйгээ харсан зөв алхам юм гэж гадны судлаачид зөвлөсөн нь учиртай.

Байгалийн нөөц баялгаа хөгжилд хүргэх гишгүүр болгон хувиргахын тулд бидэнд дараах асуудалд ихээхэн болгоомжтой хандах нь чухал хэмээн үзсэн судлаачдын байр суурьтай хамтатган өөрийн бодлоо хүргэе. Үүнд:

Юуны өмнө улс орны аюулгүй байдал, хөгжил дэвшлийн үндэс болсон эрдэс баялгийн асуудлыг улс төржүүлж хурцдуулахгүй байх, үндэсний нарийн мэргэжлийн эрдэмтэд судлаачдыг бэлтгэх зэрэг асуудлыг бодлогын хүрээнд авч үзэж даруйхан шийдвэрлэх нь чухал байна.

Уул уурхай дахь гадаад хөрөнгө оруулалт, түүний дотор лиценз олгох асуудал Монгол улсын ирээдүйн хувь заяа, эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц асуудал тул маш анхаарал болгоомжтой хандах. Өнөөгийн байдлаар хөрш хоёр орон (ОХУ-248, БНХАУ-232) эзэмшиж буй лицензийн тоогоороо, оруулсан хөрөнгө оруулалтаараа тэргүүлж яваагийн хувьд ашиг сонирхлоо хамгаалах шаардлага гарвал улс төр, дипломатын хүчтэй шахалт үзүүлэх магадлал өндөр байна.

Цаашид ч энэ улсуудын цэрэг, эдийн засгийн хүч чадал, дэлхийн бодлогод эзлэх байр суурь өсөхийн хирээр энэ аюул занал нэмэгдэх боломжтой гэдгийг анхаарах нь чухал юм.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортлох үнэ, ялангуяа нүүрс, цайр, төмрийн хүдэр гэх мэт нийтэд төдийлөн таньж мэдэгдээгүй ашигт малтмалын үнэ, цаашид нийт экспортын үнийг хянан зохицуулах механизм бий болгох, эсвэл Эрдэс баялгийн зөвлөлийн эрх хэмжээг өргөтгөн, зөвхөн нөөц батлах бус ашигт малтмалын үнэ ханш, найрлага, тоо хэмжээнд хяналт тавьдаг болгон өөрчлөх хэрэгтэй.

Гадаад бодлого, аюулгүй байдлын асуудлаа уул уурхайн салбарын хөгжилтэй нягт холбох, үүний тулд зэс, жонш, нүүрс, эрчим хүчний гэх мэт хөтөлбөр боловсруулж, тэр чиглэлийн дипломат бодлого боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй.

Хөрөнгө оруулалт, ялангуяа хил орчмын томоохон уул уурхайн төслүүдэд дэлхийн нөлөө бүхий их гүрнүүд, уул уурхайн томоохон компаниудыг түлхүү оруулах асуудлыг онцлон авч үзэх хэрэгтэй бөгөөд энэ нь улс орны тусгаар тогтнол, хил хязгаарын аюулгүй байдалд стратегийн чухал ач холбогдолтой болохыг анхаарах нь чухал юм.¹²

Нөөцийн эдийн засгийн талаар сургалтын хөтөлбөр боловсруулж их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт нэвтрүүлэх замаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах.

Төв Ази болон хуучин социалист системийн улс орнуудтай хамтран нөөцийг зүй зохистой удирдаж, байгалийн нөөцийн хясланг хамтарч удирдах бүс нутгийн институцийг бүрдүүлэхэд идэвхи санаачилгатай оролцох.

Дотоодын институцийг эрүүлжүүлэхэд иргэний нийгэм, төр засаг, сургалт судалгааны байгууллага, эрдэмтэн судлаачдын оролцоог нэмэгдүүлж, олон нийтийг гэгээрүүлэх, улмаар

¹¹ Thorvaldur Gylfason: "Natural resources, education and economic development" www.elsevier.com

¹² Д.Шүрхүү: "Эрдэс баялагийн геополитик" Олон улс судлал сэтгүүлийн 2006 оны дугаар

нөхцөл байдалд тавих хяналтыг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч зохион байгуулах нь чухал байна.

Эцэст нь онцлон тэмдэглэхэд төрийн зөв бодлого, хуулийн зөв зохицуулалт, зөв менежмент, зөв хуваарилалтыг даруйхан хийхгүй бол улс орны улс төр, эдийн засаг, экологийн аюулгүй байдалд ноцтой аюул учрах, ялангуяа их гүрнүүд, үндэстэн дамнасан корпорациудын өрсөлдөөн, зөрчилдөөнд татагдан орох магадлал өндөр байна.